ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЗӨВЛӨЛ

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЗӨВЛӨЛ

2022

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТАЙЛАН

2023 он

ӨМНӨТГӨЛ

Хэвлэл мэдээллийн зөвлөл (ХМЗ) нь:

- Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг дэмжих
- Нийгэмд сэтгүүлчид болон хэвлэл мэдээллийн байгууллагуудын хариуцлагыг бий болгох
- Сэтгүүл зүйн салбарт ёс зүй болон мэргэжлийн стандартыг хөгжүүлэх
- Сэтгүүлчдийн хараат бус байх эрхийг хамгаалах зорилгын дор үйл ажиллагаа явуулдаг сэтгүүлч, ажил олгогч, салбарын эвсэл холбоод, мэргэжлийн байгууллагуудын санаачилга, амжилттай хамтын ажиллагааны үр дүнд 2015 оны эхээр байгуулагдсан хэвлэмэл, цахим, радио, телевизийн хараат бус, өөрийн зохицуулалтын байгууллага юм.

2022 онд Хэвлэл мэдээллийн зөвлөл нь хэвлэл мэдээллийн байгууллага, редакцын мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, иргэн, байгууллага аж ахуйн нэгжээс редакцын нийтлэл, нэвтрүүлэгт гаргасан өргөдөл гомдлыг барагдуулах үндсэн чиг үүргээ амжилттай хэрэгжүүллээ.

2022 онд ХМЗ-д иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 65 өргөдөл гомдол ирүүлснийг Ёс зүйн хороод 7 удаагийн хурлаар хэлэлцэн шийдвэрлээд байна.

ХМЗ-ийн Удирдах зөвлөл хэвлэл мэдээллийн эрх зүйн орчинг сайжруулах, хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах, хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтыг бэхжүүлэх, хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын үйл ажиллагаанд чанарын удирдлагыг нэвтрүүлэх зэрэг бодлогын шийдвэрүүдийг гаргаж ажиллалаа.

Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт, ёс зүйн зарчим, чанарын удирдлага зэрэг сэдвийн хүрээнд ХМЗ-ийн гишүүд, ажлын албанд 4 удаагийн сургалт, хэвлэл мэдээллийн байгууллага/редакцуудад 8 удаагийн уулзалтыг зохион байгууллаа.

Сэтгүүл зүйн чанарын тухай хэвлэл мэдээллийн салбарынхан болон олон нийтэд зориулсан сургалт, хэлэлцүүлэг, дугуй ширээний ярилцлагуудыг тогтмол зохион байгуулав. 2022 онд ХМЗ-өөс 100 орчим сургалт, арга хэмжээ зохион байгуулж 2000 орчим сэтгүүлч, редактор, сурвалжлагч, иргэний нийгмийн төлөөлөлд хүрч ажиллажээ.

Хэвлэл мэдээллийн зөвлөлийн үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй байлгах бодлогын хүрээнд 4 удаагийн цахим сэтгүүл бэлтгэн 700 гаруй хүнд тогтмол хүргэлээ. Түүнчлэн өдөр тутмын үйл ажиллагааг вэб сайт, пэйж хуудсаараа дамжуулан түгээж байна.

Салбарын эвсэл, холбоод, редакторууд болон дотоод, гадаадын түншлэгч байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлж ажиллав.

01

ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭЛТ

Хэвлэл мэдээллийн зөвлөл нь Сонин, сэтгүүл, сайтын Ёс зүйн хороо, Радио телевизийн Ёс зүйн хороотойгоор үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг бөгөөд тус хороод нь иргэн, байгууллагаас ирүүлсэн гомдлыг ХМЗ НҮТББ-ын дүрэм, Үйл ажиллагааны журам, Гомдол хүлээн авах, барагдуулах журам, Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчимд тулгуурлан хэлэлцэж дүгнэлтээ гаргадаг.

Хэвлэл мэдээллийн зөвлөл 2015 оноос 2022 оныг дуустал нийт 522 өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэжээ.

2022 оны нэгдүгээр сараас арванхоёрдугаар сар хүртэлх хугацаанд нийт 65 өргөдөл гомдлыг хүлээн авсан. Үүнээс:

- РТВ-ийн Ёс зүйн хороо 7 (16%)
- ССС-ын Ёс зүйн хороо 36 (84%)

гомдлыг тус тус хэлэлцсэн байна.



ХМЗ-өөс өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн байдал:

Нийт 65 өргөдлийн 16-г ГХАБЖ-ын 2.3–ын дагуу хугацаа хэтэрсэн, материалаа бүрэн бүрдүүлж өгөөгүй, ХМЗ-ийн чиг үүрэгт хамаарахгүй, гомдол үндэслэлгүй зэрэг шалтгаанаар Ажлын албанаас урьдчилсан хяналт хийж шийдвэрлэсэн.
4 гомдол гаргагч өргөдлөө буцаан татсан. Жилийн эцсээр ирсэн хоёр гомдлыг 2023 оны 1-р улирлын хурлаар хэлэлцүүлэхээр түр хойшлуулав.
Ингээд 43 сэтгүүл зүйн бүтээлд хаягласан гомдлыг хоёр Хороодын долоон удаагийн хуралдаанаар хэлэлцэж, ГХАБЖ-ын 6.3-ийн дагуу дараах дүгнэлтийг гаргасан.

1) ГХАБЖ-ын 6.3.1–ийн дагуу 7 редакцыг Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим зөрчөөгүй гэдгийг олон нийтэд мэдээлэх;
2) ГХАБЖ-ын 6.3.2-ын дагуу 9 редакцыг зөрчлөө өөрсдөө залруулсан, уучлал гуйсныг мэдэгдэж, нэрийг дурдахгүйгээр олон нийтэд мэдээлэх;
3) ГХАБЖ-ын 6.3.3-ийн дагуу 8 редакцыг Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим зөрчсөн тул нэрийг дурдаж олон нийтэд мэдээлэх;

Мөн нэг гомдол гаргагч 13 редакцад хаяглан ирүүлсэн гомдлоо гомдлыг хэлэлцэх явцад буцаан татсан бол нэг гомдол гаргагчаас таван редакцад хаяглан ирүүлсэн гомдлыг Ёс зүйн хороо хэлэлцээд материал дутуу хэмээн буцаасан болно. Түүнчлэн өөр нэг гомдлыг хэлэлцэх үндэслэлгүй гэж үзсэн.
Ёс зүйн хороодын дүгнэлтээс харахад хариуцагч хэвлэл мэдээллийн редакцууд Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын дараах заалтуудыг нийтлэг зөрчжээ. Үүнд:

- 1-т заасан “Олон түмэнд үнэнд нийцсэн мэдээлэл хүргэх, хүнлэг ёс, хүн чанарыг эрхэмлэх нь сэтгүүл зүйн эрхэм дээд үнэт зүйл мөн. Мэдээллийг нягтлах нь сэтгүүл зүйн нягт, нямбай үйл ажиллагааны үндсэн зарчим болно”,
- 1.1-т заасан “Мэдээлэл нь үнэнд нийцсэн эсэхийг баталгаажуулж, санамсаргүй алдаа гаргахаас зайлсхийнэ”,
- 1.2-т заасан “Эх сурвалжийн баталгаатай эсэхийг нягталж, тодорхой дурьдахыг эрмэлзэнэ” гэсэн заалтууд багтаж байна.

ХМЗ-д гомдол гаргагсдыг ангилж харвал:

- Хувь хүн 46 хувь,
- Улс төрч, төрийн албан хаагч, төрийн байгууллага 11 хувь,
- Бизнесийн байгууллага 43 хувь байна.



02

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БОДЛОГЫН ШИЙДВЭРҮҮД:

ХМЗ-ийн Удирдах зөвлөл нь сонин/сэтгүүл, радио/телевиз, цахим сайтууд, орон нутгийн хэвлэл мэдээлэл, олон нийт/санаачлагчдын бүлэг гэсэн таван салбар бүлгийг төлөөлөх 15 хүний бүрэлдэхүүнтэй.

ХМЗ НҮТББ-ын дүрмийн 10.2-т заасны дагуу ажлын албанаас санал оруулсан үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг батлах, гүйцэтгэлд хяналт тавих, зөвлөмж чиг үүрэг өгөхөөс гадна хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах, хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтыг бэхжүүлэхтэй холбоотой бодлогын шийдвэрүүдийг гаргаж ажиллалаа.

2022 онд ХМЗ-ийн Удирдах зөвлөл хоёр удаагийн хурал, нэг удаагийн уулзалт хийж, дараах бодлогын баримт бичгүүдийг хэлэлцэн баталжээ.

1) Удирдах зөвлөлийн даргаар У.Тамирыг, дэд даргаар С.Шаравдоржийг сонгов (2-р сарын 18)
2) Удирдах зөвлөлд Радио, телевизийн сэтгүүлчдийг төлөөлөх гишүүнээр С1 телевизийн Программын албаны дарга Г.Тэгшжаргалыг, сонин, сэтгүүлийн эзэн/эрхлэн гаргагчдыг төлөөлөх гишүүнээр Зууны мэдээ сонины ерөнхий эрхлэгч Д.Отгонбаярыг, олон нийтийн төлөөллөөр МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн профессор, доктор О.Мөнхсайхан, Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн Сэтгүүл зүйн багш, профессор, доктор Л.Ариунаа нарыг, РТВ-ийн ёс зүйн хороонд олон нийтийн төлөөллөөр МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн багш, доктор Т.Өнөрсайхан нарыг сонгов (2-р сарын 18)
3) 2021 оны үйл ажиллагаа болон санхүүгийн жилийн тайланг хэлэлцэн дүгнэж, 2022 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг батлав (2-р сарын 18)
4) 2022 оны эхний хагас жилийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг хэлэлцэн дүгнэж, хоёрдугаар хагас жилийн төлөвлөгөө төсвийг батлав (7-р сарын 4)
5) Удирдах зөвлөлд радио, телевизийн эздийг төлөөлөх гишүүнээр Монголын хүйн радиогийн холбооны захирал Ц.Оюунтунгалаг, РТВ-ийн ёс зүйн хороонд радио, телевизийн эздийг төлөөлөх гишүүнээр Монгол Телевиз ХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Бат-Эрдэнэ, Шинэ долгион ФМ 107.5 радиогийн захирал Ц.Ариунаа нарыг, олон нийтийг төлөөлөх гишүүнээр МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн багш, доктор Д.Идэржаргалыг тус тус сонгов (7-р сарын 4)
6) Зөвлөлдөх уулзалтаар Хэвлэл мэдээллийн зөвлөлийн үндсэн үйл ажиллагаанд Чанарын удирдлагын менежмэнтийг нэвтрүүлэх бодлогын баримт бичгийг танилцуулж, хэлэлцүүлэг өрнүүлэв (10-р сарын 25)
7) Хэвлэл мэдээллийн зөвлөлийн бие даасан хараат бус байдлыг дэмжих, тогтвортой байдлыг хангах стратегийн чиглэлийг танилцуулж, санал солилцов (10-р сарын 25)

03

СЭТГҮҮЛ ЗҮЙН ЁС ЗҮЙН ФОРУМ

Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс “Сэтгүүл зүйн ёс зүйн форум”-ыг дөрөв дэх удаагаа амжилттай зохион байгууллаа. Хоёрдугаар сарын 24-нд болсон энэхүү форумд сэтгүүлч, редакторуудаас гадна салбарын эвсэл, холбоод, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл гээд нийт 80 гаруй хүн оролцлоо.

Ёс зүйн форум нь тухайн жилийнхээ онцлог сэдвүүдээс сонгон хөндөж, бодлогын санал зөвлөмж гаргахад чиглэдэг, хэвлэл мэдээллийн салбарынхан асуудлаа хамтдаа хэлэлцэж, гарц шийдлээ дэвшүүлдэг онцлогтой билээ. Энэ жилийн хувьд “КОВИД-19: Мэдэх эрх, сэтгүүлчийн ёс зүй” сэдвийн хүрээнд болж өнгөрөв. Учир нь дэлхийн аль ч улс оронд, хаана ч, хэнд ч цар тахлыг хохирол багатайгаар даван туулах туршлага, арга зам байсангүй. Бусад оролцогч талуудын нэгэн ижил хэвлэл мэдээллийнхэн нийгмийн өмнө хүлээсэн иргэний мэдэх эрхийг хангах, мөн хяналт тавих “хоточ банхар”-ын үүргээ амаргүй нөхцөл байдалд биелүүлэхийн төлөө хичээн ажиллаж, олон сорилыг туулсан. Тиймээс хэвлэл мэдээллийн салбарын сорилт, сургамжийн талаар хамтдаа хэлэлцэхийг энэ удаагийн форумаар зорьсон юм.

Түүнчлэн энэхүү форумд “Цар тахлын үеийн хэвлэлийн эрх чөлөө, сэтгүүлчийн ёс зүй”, “КОВИД-19: Сэтгүүл зүйн үүрэг, ёс зүй, хамтын ажиллагаа”, “Цар тахлын үед аюулд өртөөд буй мэдэх эрх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө: олон улсын сургамж” сэдэвт гурван илтгэл, мөн оролцогч талуудын хэлэлцүүлгээр дамжуулан нөхцөл байдлыг хэлэлцэв. Форумаар хэлэлцсэн асуудлыг 10 гаруй хэвлэл мэдээллийн байгууллагууд сурвалжилж, мэдээ, нийтлэл гаргасан. Мөн форумаар хэлэлцсэн асуудлаас улбаалсан хямралын үеэр бүх хүнд хүртээмжтэй хэлбэрээр, хоёрдмол утгагүйгээр мэдээллийг тухай бүр өгч байх үүргээ хэрэгжүүлэх зөвлөмжийг Монгол Улсын Засгийн Газар, эрх бүхий байгууллагууд, хэвлэл мэдээллийнхэнд хандан гаргаад байна.

04

“ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БОДЛОГО” ЦУВРАЛ ДУГУЙ ШИРЭЭНИЙ ЯРИЛЦЛАГА

Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс Фридрих-Эбертийн Сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газартай хамтран “Хэвлэл мэдээллийн бодлого” цуврал дугуй ширээний ярилцлагыг 2018 онд эхлүүлсэн. Уг уламжлалын дагуу 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдөр “Шинэ геополитик Монголд” сэдвийн хүрээнд болж өнгөрлөө. Энэ удаагийн дугуй ширээний ярилцлагыг Стратеги судалгааны хүрээлэнтэй хамтран зохион байгуулсан юм.

Дугуй ширээний ярицлагын эхний хэсэг “Геополитик” сэдвийн хүрээнд явагдаж, Дипломат академийн захирал, Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Х.Бэхбат “Геополитикийн үндсэн ойлголт, оролцогч талууд, ирээдүйн хандлага” сэдвийн хүрээнд, олон улсын харилцаа судлаач, нийтлэлч, доктор Д.Баярхүү “Монгол Улс ба геополитик” сэдвээр мэдээлэл, танилцуулга хийсэн юм.

Хоёрдугаар хэсэг “Хэвлэл мэдээлэл” сэдвээр үргэлжилж, олон улсын харилцаа судлаач, сэтгүүлч Ц.Сувданцэцэг “Геополитик ба хэвлэл мэдээлэл”, News.mn агентлагийн ТУЗ-ийн гишүүн, Хэвлэл мэдээллийн зөвлөлийн хараат бус зөвлөх Д.Нарантуяа “Геополитикийн шинэ нөхцөл байдлыг хэрхэн мэдээлж байна вэ” сэдвийн хүрээнд тус тус илтгэл тавилаа.

Уулзалт нь хэвлэл мэдээлэл болон геополитикийн уялдаа холбоо, харилцан үйлчлэл, түүнчлэн өнөөгийн гадаад орчны хурцадмал байдалд Монголын хэвлэл мэдээлэл хэрхэн ажиллах вэ зэрэг асуудлыг хөндсөн хэлэлцүүлгээр үргэлжилсэн юм. “Шинэ геополитик Монголд” дугуй ширээний ярилцлагад геополитик судлаачид, хэвлэл мэдээллийн редакторуудаас бүрдсэн 40 гаруй хүн оролцлоо.

05

СЭТГҮҮЛ ЗҮЙН ЧАНАРЫН ЦУВРАЛ СУРГАЛТ, УУЛЗАЛТУУД

1-12 дугаар сар

ХМЗ-ийн ажлын албанаас редакцуудын уулзалтыг тогтмол хийж, нийт 8 хэвлэл мэдээллийн байгууллагад зочлон, хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт, ёс зүйн зарчим, сэтгүүлчийн аюулгүй байдлын талаар мэдээлэл хийлээ. Үүнд: Asu.mn, Mpress.mn, Ikon.mn, Bolod.mn мэдээллийн сайтууд, Улстөрч агентлаг, Зууны мэдээ сонин, TB8 телевиз болоод Гэрэл плас медиа групп ХХК-ийн Парламент ТВ, Gerelnews.mn мэдээллийн сайт багтаж байна.



4-5 дугаар сар

Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс 2022 онд НҮБ-ын Монгол дахь Суурин зохицуулагчийн газартай хамтран сэтгүүлчдийн тогтвортой хөгжлийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх “ЁС ЗҮЙТ ЭРЭН СУРВАЛЖИЛГА: ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ” сэдэвт цуврал сургалт, сэтгүүл зүйн ёс зүйн шаардлага хангасан бүтээл бэлтгэн түгээх ажлыг тус тус зохион байгуулсан. Ингэхдээ ЮНЕСКО болон НҮБ-тай хамтран сэтгүүлчдийн эрэн сурвалжлах чадавхийг дээшлүүлэх, тогтвортой хөгжлийн зорилгуудтай холбоотой мэдлэг олгох вакумжуулсан цуврал сургалтууд хийв. Гурван өдрийн цуврал вакумжуулсан сургалтад 30 сэтгүүлч, редактор хамрагдсан. Сургалтаар хүний чанартай амьдралын төлөөх хөгжлийн бүхий л асуудалд чиглэсэн тогтвортой хөгжлийн зорилгуудын хүрээнд “хөгжлөөс хэнийг ч орхихгүй байх” зарчим, “тэгш бус байдал”-ын асуудалд илүү төвлөрч мэдээлэл хүргэлээ. НҮБ, түүний системийн байгууллагуудын мэргэжилтнүүд боловсрол, эрүүл мэнд, бизнес ба хүний эрх, зохистой хөдөлмөр, нийгмийн хамгаалал, агаар орчны бохирдол, шилжин суурьшилт гэх мэт асуудлуудын хүрээнд сүүлийн үеийн мэдээлэл, судалгааг хуваалцав.

Тавдугаар сар

“Монгол Улс дахь хэвлэл мэдээллийн эрх чөлөөний өнөөгийн байдал ба түүнийг олон улсын сайн жишигт нийцүүлэх нь” судалгааны тайлангийн хавсралт буюу Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын загвар төслийг Хэвлэл мэдээллийн зөвлөлийн Удирдах зөвлөлийн гишүүд хэлэлцлээ. Ингэхдээ 2022.05.06-ны өдөр уг төслийг нягтлан хэлэлцэж, санал солилцсоны үндсэн дээр “Иргэдийн оролцоо” төсөлд санал боловсруулан хүргүүллээ.

Тавдугаар сар

Хэвлэл мэдээллийн зөвлөлийн гишүүд “Хэвлэлийн эрх чөлөөний индекс: Ухралт, шалтгаан, үр дагавар” сэдэвт цахим уулзалт хийлээ. Энэ үеэр ХМЗ-ийн хуульч Л.Галбаатар “Хэвлэлийн эрх чөлөө-2022, Монгол улсын үзүүлэлт” сэдвээр илтгэл танилцуулав. Уулзалтад ХМЗ-ийн удирдах зөвлөлийн болон ёс зүйн хороодын гишүүд, ажлын алба, төслийн багийнхан оролцов. Ингэхдээ хэвлэлийн эрх чөлөөний индексийн шалгуур үзүүлэлтүүдийн нэг болох “Улс төрийн нөхцөл байдал” сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлж хэвлэл мэдээлэл дэх улс төрийн ашиг сонирхлын нөлөөлөл, эзэмшлийн ил тод байдал, хэт төвлөрлийн асуудлаар санал бодлоо солилцлоо. Оролцогчид хэвлэл мэдээллийн санхүүгийн баталгаагүй, тогтворгүй байдал нь улс төрийн хамааралд оруулж буйг онцолсон. Иймд редакцууд нэгдэж чанартай контент үйлдвэрлэх, олон нийтийн итгэлийг олох, хэрэглэгчиддээ контентоо борлуулах, тэднээс хандив дэмжлэг авах нь улс төрийн ашиг сонирхлоос ангид байх гарц гэдгийг хуваалцлаа. Түүнчлэн ОНРТ болон ХХЗХ-ны хараат бус байдлын баталгаа нь энэхүү шалгуурыг хангахад чухал нөлөөтэйг дурдлаа.





Аравдугаар сар

Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс 2022 онд шинээр сонгогдсон гишүүддээ зориулсан чадавхжуулах сургалтыг зохион байгууллаа. Сургалтад тус зөвлөлийн удирдах зөвлөл, ёс зүйн хороодод сонгогдсон таван хүн хамрагдаж, хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт, иргэнээс ирүүлсэн өргөдөл гомдлыг журмын дагуу хэрхэн хэлэлцэн дүгнэлт гаргадаг, ёс зүйн зарчим ба кейс менежмент, редакцуудын гаргадаг түгээмэл алдаа зэргийн талаар мэдээлэл авсан юм.

Арваннэгдүгээр сар

Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт, ёс зүйн сургагч багш бэлтгэх цуврал сургалтыг эхлүүллээ. Анхны сургалтыг 11 дүгээр сарын 8-нд зохион байгуулж, нийт 10 хүнийг хамруулав. ХМЗ-ийн гишүүдээс бүрдсэн сургагч багш нарын багийг чадавхжуулах сургалтыг Ёс зүйн хорооны орлогч дарга, сургагч багш Ц.Чимиддондог удирдан явууллаа.



Арваннэгдүгээр сар

Хэвлэл мэдээллийн зөвлөл нь хагас жил тутамд бүх гишүүддээ зориулсан чадавхжуулах сургалтыг тогтмол хийдэг билээ. Энэ удаагийн сургалтыг 11 дүгээр сарын 12, 13-ны өдрүүдэд Монголика ресортэд зохион байгууллаа.

Сургалтад ХМЗ-ийн Удирдах зөвлөл, ёс зүйн хороод болон ажлын албаны 30 орчим төлөөлөл хамрагдаж, 2022 оны эхний гурван улирлын үйл ажиллагааны тайлан, 2023 оны үйл ажиллагааны чиглэлтэй танилцаж, “Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим”-д оруулах өөрчлөлт, цаашид анхаарах чухал ажлуудаа хэлэлцлээ. Сургалтаар:

- ХМЗ-ийн өргөдөл гомдол барагдуулах үйл ажиллагааны явц, анхаарах асуудлууд,
- Кэйс менежмэнт - “Ёс зүйн хороодын 2022 онд шийдвэрлэсэн гомдлуудад хийсэн дүгнэлт, чанарыг баталгаажуулах санал зөвлөмж”,
- Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын 1.1 дэх заалтыг хэрхэн ойлгох вэ?,
- “ХМЗ-ийн үйл ажиллагаанд чанарын удирдлагын менежмэнтийг нэвтрүүлэх бодлогын баримт бичиг”,
- “Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим ба нийтлэг алдаа”,
- Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчимд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хэлэлцүүлэг,
- 2022 оны эхний гурван улирлын үйл ажиллагааны тайлан, 2023 оны үндсэн чиглэл сэдвээр тус тус хэлэлцүүлэг өрнүүлэв.

Гишүүдийн зүгээс энэ удаагийн сургалтаар гомдол гаргагчдын хамгийн их зөрчсөн гэж үздэг “Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим”-уудыг задарган хэлэлцсэн нь үр дүнтэй байсан хэмээгээд бусад заалтуудыг ч мөн цувралаар хэлэлцээд өөрчлөлт оруулж, шинэчлэх хэрэгцээ шаардлага байгааг онцоллоо.

Арваннэгдүгээр сар

Арваннэгдүгээр сард “Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын үр дүн, ач холбогдол” сэдвийн хүрээнд зохион байгууллаа. Уулзалтаар хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын үр дүн, ач холбогдол, ХМЗ-ийн Ёс зүйн хороодын шийдвэрийн тойм, тэдгээрт хийсэн дүн шинжилгээ, ХМЗ-ийн гомдол хүлээн авах, барагдуулах үйл ажиллагааны талаар мэдээлэл өгч, оролцогчид салбарын өөрийн зохицуулалтыг бэхжүүлэх арга замуудын талаар ярилцлаа. Тодруулбал, ХМЗ-ийн гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа “Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын үр дүн, ач холбогдол”, ХМЗ-ийн хараат бус зөвлөх Д.Нарантуяа “ХМЗ-д ирсэн гомдлуудад хийсэн дүн шинжилгээ”, ХМЗ-ийн ёс зүйн мэргэжилтэн О.Дүүрэнжаргал “Хэвлэл мэдээллийн зөвлөлийн гомдол хүлээн авах, барагдуулах үйл ажиллагаа” сэдвээр мэдээлэл өгөв. Оролцогчдын зүгээс нягтлан шалгах үйл ажиллагаанд төрийн мэдээллийн ил тод бус, нээлттэй биш байдал саад болж байгаа талаар болоод салбарт тулгамдаж буй хэд хэдэн чухал асуудлыг хөндөн ярилцсан юм.

Арванхоёрдугаар сар

Дойче Велле Академи болон Фридрих-Эбертийн сангийн дэмжлэгтэйгээр “Ардчиллын тулгуур багана: хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтыг тогтвортой хөгжүүлэх нь” сэдэвт дугуй ширээний ярилцлага 12 дугаар сарын 6-нд Бельги улсад боллоо. Уг уулзалтад Хэвлэл мэдээллийн зөвлөлийн удирдах зөвлөлийн дарга У.Тамир, дэд дарга Шаравдорж, гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа нар оролцон хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын үйл ажиллагаа, ололт амжилт, туршлагаасаа хуваалцсан юм. Түүнчлэн оролцогч талууд хэвлэл мэдээллийн салбарт ёс зүй болон мэргэжлийн стандартыг хөгжүүлэх, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хамгаалах, нийгэмд сэтгүүлчид болон хэвлэл мэдээллийн байгууллагуудын хариуцлагыг бий болгох асуудлаар дэлгэрэнгүй хэлэлцүүлэг өрнүүлэв.

Бельгийн Вант улсын нийслэл Брюссель хотноо болсон уг уулзалтад Монгол Улсаас Люксембургийн Их Гүнт Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Л.Болд, Европын холбооноос

Монгол улсад суугаа элчин сайд Аксель Никэйз, Дойче Велле Академийн захирал Карстен Вон Нахмен, ХБНГУ-ийн Хэвлэлийн зөвлөлийн орлогч дарга Манфред Протце, ДВА-ийн Монгол дахь төслийн менежер Патрик Беннинг, ДВА-ийн Монгол дахь төслийн зохицуулагч Дина Силбэк, Х.Ариунчимэг нар оролцсон юм.

Түүнчлэн ХМЗ-ийн удирдлагын баг ХБНГУ-ын Бонн хотноо Дойче Веле Академийн төв байраар зочилж, хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт, хямралын мэдээллийн харилцаа төслүүдийн удирдлага, багийн гишүүдтэй уулзаж харилцан санал солилцлоо.

11-12 дугаар сар

Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс 11 дүгээр сарын 3-наас 12 дугаар сарын 20-ны өдрүүдэд “Ёс зүйтэй нягталъя”, “Гэмт хэрэг ба ёс зүй”, “Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын үр дүн, ач холбогдол”, “Хэвшмэл ойлголтыг таньж мэдэх” нь цуврал сургалт, хэлэлцүүлгийг сэтгүүлчдэд зориулан зохион байгууллаа. Ингэхдээ орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагын тэгш оролцоог хангах зорилгоор танхимын сургалтыг цахимтай хослуулав. Энэ удаагийн цуврал сургалтуудыг Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмаас 1, 3, 4, 6 дугаар зарчмууд дээр гардаг түгээмэл алдаануудыг тайлбарлах, кэйс хэлэлцүүлэг өрнүүлэх зорилгоор Соёлын яамны дэмжлэгтэйгээр “Бүх нийтийн соёлын боловсрол” олгох ажлын хүрээнд зохион байгуулсан юм.

06

ОЛОН НИЙТЭД ХАНДСАН АЖЛУУД

I cap

Засгийн газраас 2021.11.24-ний өдөр Улсын Их Хуралд Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг өргөн барьж, Улсын Их Хурлын чуулганы 2022.01.06-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэж эхэлсэн. Үүнтэй холбоотойгоор ХМЗ-өөс Монгол улсын ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, УИХ-ын дарга Г.Занданшатар болон УИХ-ын гишүүдэд шаардлага хүргүүлэв.

I cap

“Зууны мэдээ” сонинд Хэвлэл мэдээллийн зөвлөлийн гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаагийн “Эрх зүйн болон өөрийн зохицуулалт хамт хөгжсөнөөр хэвлэлийн эрх чөлөө төлөвшинө” гарчигтай ярилцлага нийтлэгдэв.

II cap

Сэтгүүл зүйн ёс зүйн форумаар хэлэлцсэн асуудлын талаар ХМЗ гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа ММ агентлагт ярилцлага өгөв.

IV cap

Монголын Үндэсний Сайтын Хөгжлийн Нэгдсэн Холбооноос зохион байгуулсан уулзалтад “Хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин ба өөрийн зохицуулалт” сэдвээр илтгэл танилцуулав. Уулзалтад МҮСХНХ-ны удирдах зөвлөлийн гишүүд болон 30 гаруй гишүүн сайтуудын төлөөлөл оролцов.

IV cap 29

News.mn сайтаас зохион байгуулсан "Цахим сэтгүүл зүйн форум"-ийн Сошиал медиа ба сэтгүүл зүй хэлэлцүүлэгт ХМЗ-ийн гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа оролцож дижитал орчин сэтгүүл зүйд авчирч буй боломж, саад бэрхшээл, мөн сошиал медиад мэргэжлийн сэтгүүл зүйн ялгарах онцлогийн талаар ярилаа.

V cap 3

Глоб Интернэшнл төвөөс зохион байгуулсан "Цахим дайралт дахь Монголын хэвлэл мэдээллийн өнөөгийн байдал" хэлэлцүүлэгт ХМЗ-ийн гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа панелистаар оролцов.

V cap 3

Монголын сайтын холбооноос зохион байгуулсан "Цахим бүслэлт - Нийгмийн сэтгэл зүй" IV чуулганд ХМЗ-ийн гүйцэтгэх захирал оролцон "Сэтгүүлчийн ёс зүйн код - Гэмт хэргийг мэдээлэх нь" сэдвээр илтгэл тавьж, хэлэлцүүлэгт панелистаар оролцов.

X cap 3

Онцгой байдлын ерөнхий газраас НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран аравдугаар сарын 4-ний өдөр зохион байгуулсан "Коронавируст халдварын цар тахлын үеийн удирдлага, зохион байгуулалт, туршлага, сургамж, цаашдын чиг хандлага" сэдэвт хуралд ХМЗ-ийн удирдлага оролцож "Хямралын үеийн мэдээллийн харилцаа, оролцогч талуудын хамтын ажиллагаа" сэдвээр илтгэл танилцуулав.

XI cap **2**

“Сэтгүүлчдийн эсрэг гэмт үйлдэл ял шийтгэлгүй үлдэж буйг таслан зогсоох олон улсын өдрийг тохиолдуулан 11 сарын 2-ны өдөр “Хэвлэл мэдээллийг хамгаалж ардчиллыг дэмжье” хурлыг Глоб Интернэшнл төв, ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисс, Нээлттэй нийгэм форумтай хамтран зохион байгуулсан. Уг хурлын үеэр болсон “Сэтгүүлчдийн аюулгүй байдал ба үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах эрх чөлөө” хэлэлцүүлэгт ХМЗ-ийн гүйцэтгэх захирал панелистээр оролцов.

XI cap

Соёлын яам болон Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газар хамтран арваннэгдүгээр сарын 16-ны өдөр зохион байгуулсан “Хүний эрхийн хамгаалал, соёлын гүйцэтгэх үүрэг” хэлэлцүүлэгт ХМЗ-ийн Ёс зүйн хорооны гишүүн Э.Энэрэл оролцож “Гэмт хэрэг ба ёс зүй” сэдвээр илтгэл танилцуулаа.

XI cap **22**

Соёлын яамнаас хэрэгжүүлж буй “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн сар” аяны хүрээнд зохион байгуулсан форумын “Бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэх арга зам ба боломж” салбар хуралдаанд ХМЗ-ийн хараат бус зөвлөх Д.Нарантуяа оролцлоо.

XII cap

Зууны мэдээ” сонинд ХМЗ-ийн төслийн менежер Н.Ганчимэгийн “Хямралын мэдээллийн харилцааны багийг байгуулснаар хэвлэлийн эрх чөлөөг бэхжүүлнэ” гарчигтай ярилцлага өгөв.

Гомдол хүлээж авах, барагдуулах журмын хэрэгжилтийн дагуу ХМЗ-ийн хүлээн авч, шийдвэрлэсэн өргөдөл гомдлуудыг хэрхэн шийдвэрлэсэн талаар 7 удаагийн хэвлэлийн мэдээ бэлтгэж, олон нийтэд нээлттэйгээр байршууллаа. (http://www.mediacouncil.mn/as/shiidver) Мөн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр түгээв.





I сар ... XII сар

Хэвлэл мэдээллийн зөвлөлийн үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй байх бодлогын хүрээнд улирал тутам цахим сэтгүүл гаргаж, олон нийтэд түгээж байна. Өнгөрсөн онд нийт дөрвөн дугаар гаргаж дотоодын 700 гаруй, гадаадын 100 орчим хүнд илгээв.

07

“ХЯМРАЛЫН МЭДЭЭЛЛИЙН ХАРИЛЦАА БА ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА” ТӨСЛИЙН ХҮРЭЭНД:

Хэвлэл мэдээллийн зөвлөл нь иргэдийн мэдэх эрхийг хангах, ёс зүйтэй, баталгаатай, найдвартай мэдээллийг түгээн дэлгэрүүлж, хэвлэлийн эрх чөлөөг бататган хамгаалахад хувь нэмрээ оруулдаг салбарын өөрийн удирдлагын байгууллага билээ. Энэ зорилгынхоо хүрээнд мэдээллийн хоёр чигт урсгалыг дэмжих, мэдээллийн хүртээмж сул, алслагдсан хороо, сумдын иргэдэд баталгаат мэдээллийн үнэ цэнийг ойлгуулах, худал ташаа мэдээллийн хор уршгийг таниулах, урьдчилан сэргийлэх, мэдээллийн харилцаанд оролцогч талуудын хамтын ажиллагааг дэмжихэд хувь нэмрээ оруулж буй юм.

Энэ хүрээнд ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн холбооны яам, Дойче Велле Академийн дэмжлэгтэйгээр “Хямралын мэдээллийн харилцаа ба оролцогч талуудын хамтын ажиллагаа” төслийг 2021-2023 онд хэрэгжүүлээд байна. Тус төсөл нь Кени, Замби, Киргиз, Молдав, Монгол зэрэг дэлхийн таван оронд хэрэгжиж буй олон улсын төсөл бөгөөд Монгол Улс хоёр дахь жилдээ амжилттай хамрагдаад байна.

Баталгаатай мэдээлэл амьдралыг аварна уриатай “Хямралын мэдээллийн харилцаа ба оролцогч талуудын хамтын ажиллагаа” хөтөлбөр амжилттай хэрэгжлээ. Хөтөлбөрийн зорилго нь хямрал, эрсдэлийн үед:

1) Иргэдийн мэдээлэл авч буй байдлыг сайжруулах, баталгаатай мэдээллээр хангах,

2) Хэвлэл мэдээлэл, орон нутгийн засаг захиргаа, иргэд, олон нийтийн төлөөллүүд нэг дор цугларч, өөрсдийн мэдлэг, харилцаа холбоог нэгтгэн, мэдээллийг нягтлах, найдвартай, хариуцлагатайгаар түгээх сүлжээ болон ажиллахад чиглэсэн. Төсөл нь хоёр шаттай хэрэгжлээ.

Нэгдүгээр шатанд:

1 шат

Төр, хэвлэл мэдээллийн, иргэний нийгмийн төлөөлөл бүхий есөн хүнтэй үйл ажиллагааны баг бүрдэж, Ковид-19 цар тахалтай холбоотой цаг үеийн хэрэгцээт баталгаатай мэдээллийг Баянзүрх дүүргийн 23 дугаар хорооны иргэдэд хүртээмжит хэлбэрээр түгээх мэдээлэл харилцааны ажлыг явуулсан юм. Мэдээлэл харилцааны ажил нь Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх арга замыг таниулах, өвчилсний дараах шинж тэмдгийг даван туулах гэсэн сэдвийн хүрээнд өрнөсөн. Багийн гишүүд нь хэвлэл мэдээллийг төлөөлж: МҮОНРТ-ийн сэтгүүлч Б.Пүрэв, Мпресс.мн сайтын ерөнхий редактор О.Ариунбилэг, Эрүүл мэндийн сэтгүүлчдийн клубийн үүсгэн байгуулагч Б.Ундрах; төрийн байгууллагыг төлөөлж: Засгийн Газрын ХМОНХГ-ын ажилтан О.Баярмаа, ОБЕГ-ын ХМОНХ ажилтан Б.Цэнд, НЭМҮТ-ийн Эрүүл мэндийг дэмжих, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх албаны дарга С.Гэрэлмаа; Иргэд, иргэний нийгмийг төлөөлж: Баянзүрх дүүргийн 23-р хорооны өрхийн эмнэлгийн эмч Г.Чанцалмаа, Ид шидийн орон цэцэрлэгийн эрхлэгч М.Мөнхцэцэг, Хэвлэл мэдээллийн зөвлөлийн төслийн менежер Н.Ганчимэг нар багтаж байна.

ХЯМРАЛЫН МЭДЭЭЛЛИЙН ХАРИЛЦАА:

ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛАГАА

Б.ПҮРЭВ
МҮОНРТ-ийн редактор, сэтгүүлч

Б.ЦЭНД
ОБЕГ-ын ХМОНХ ажилтан, сэтгүүлч

М.МӨНХЦЭЦЭГ
“Ид шидийн орон” цэцэрлэгийн эрхлэгч

О.БАЯРМАА
Засгийн Газрын ХМОНХГ-ын ажилтан

Г.Чанцалмаа
БЗД-ийн 23-р хорооны Нэмүүлэн ӨЭМТ-ийн их эмч

О.АРИУНБИЛЭГ
Мпресс.мн сайтын ерөнхий редактор

С.ГЭРЭЛМАА
НЭМҮТ-ийн ЭМДӨУС албаны дарга



Б.УНДРАХ
Сэтгүүлч

Н.ГАНЧИМЭГ
ХМЗ-ийн төслийн менежер

Мэдээлэл харилцааны ажлын хүрээнд тус хорооны иргэд, өрхийн эмнэлэг, мэргэжилтнүүдийг оролцуулсан бөгөөд мэдээллийн хуудас, гарын авлага зэрэг хэвлэмэл материалуудыг бэлтгэж, зорилтот хорооны иргэдэд түгээсэн. Түүнчлэн тус хорооны Өрхийн эрүүл мэндийн төв нь иргэдийн эрүүл мэндийн мэдээлэл хүлээн авах итгэлтэй, ойрын суваг болох тул тус эмнэлгийн Фэйсбүүк хуудсыг идэвхжүүлж, хэрэгцээт мэдээллийг хүртээмжтэй, сонирхолтой хэлбэрээр бэлтгэн, шуурхай түгээж ажиллав. Мөн Фэйсбүүк Live, ярилцлага, нийтлэл, ТВ нэвтрүүлэг зэргийг гаргасан. Түүнчлэн 87 дугаар сургуулийн сурагчдад “КОВИД-19 халдварт өвчний дараах хам шинжийг даван туулах нь” сэдэвт сургалт, дадлагыг, мөн сурагчдын дунд видео, ханын сонин, эссе бичлэгийн төрөлд “КОВИД-19 халдварт өвчний дараах хам шинжийг даван туулах нь” сэдэвт бүтээлийн уралдааныг тус тус зохион байгууллаа.

Мэдээлэл харилцааны ажил хэрэгжиж дуусаны дараа зорилтот хорооны анхан шатны нэгжүүдийн мэдээлэл харилцааны чадавхийг сайжруулах үүднээс эрсдэлийн мэдээллийн харилцаа сэдэвт сургалтыг 2022.03.18-ны өдөр зохион байгуулсан юм.

Төслийн нэгдүгээр шатны төгсгөлд, 2022.03.31-ний өдөр тус хөтөлбөрийн туршилтын үр дүнг танилцуулах, цаашдын дүр зургийг тодорхойлоход чиглэсэн өргөтгөсөн зөвлөлдөх уулзалт зохион байгуулав. Тус уулзалтад УОК, НЭМҮТ, НЭМГ зэрэг төрийн байгууллагууд, ДЭМБ, Дэлхийн банк, НҮБ, Дэлхийн банк зэрэг олон улсын байгууллагууд, хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн төлөөлөл оролцсон бөгөөд хөтөлбөрийг амжилттай хэрэгжсэн гэж дүгнэсэн. Улмаар тус хөтөлбөрийг үргэлжлүүлэн үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх, иргэдийг баталгаатай мэдээллээр хангахад төр, хэвлэл мэдээлэл, иргэний гуравласан холбоог бий болгон ажиллахыг санал нэгтэйгээр дэмжсэн юм.

"ХЯМРАЛЫН МЭДЭЭЛЛИЙН ХАРИЛЦАА:
ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА"

Хоёрдугаар шатанд:

2 шат

Хөтөлбөрийн хоёрдугаар шатанд хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөх уулзалтуудыг ЗГ, ОБЕГ, хэвлэл мэдээллийнхэнтэй зохион байгуулав. Тухайлбал, зургадугаар сард “Дайн, зэвсэгт мөргөлдөөний үеийн хэвлэл мэдээллийн ёс зүй” сэдвийн хүрээнд хийв. Уулзалтад оролцсон редакторууд үйл явцыг мэдээлэхэд хоёр талын байр суурийн тэнцвэрийг хадгалах, мэдээллийг баталгаажуулах, албан болон хөндлөнгийн эх сурвалжийг нэмэгдүүлэх зэргээр туршлагажин ажиллаж буйгаа хэллээ. Мөн зөвхөн болж буй үйл явцыг, хор хохирлыг мэдээлээд өнгөрөх бус цаана өрнөж буй зөрчлийг, учир шалтгааныг ухаж тайлбарлах, олон улсын нийгэм, эдийн засгийн асуудал гэдэг үүднээс хандах шаардлагатайг ярилцсан.

Долдугаар сард “Хуурамч мэдээлэлтэй тэмцэж буй олон улсын туршлага” сэдэвт редакторуудын ээлжит уулзалтыг Сэтгүүл зүйн Инновац, Хөгжлийн Үүр төв болон Fact Check Mongolia сүлжээтэй хамтран зохион байгуулсан. Уулзалтаар Норвегийн Осло хотноо болсон “Глобал Факт-9” олон улсын баримт нягтлагчдын хурал, ХБНГУ-ын Бонн хотод болж өнгөрсөн “Глобал медиа форум”-аар хэлэлцсэн асуудлыг хөндөн ярилцаж, аливаа хямралын үед мэдээллийг ил тод солилцох, түгээхийн чухлыг онцолсон.

Төслийн хоёрдугаар шатыг хэрэгжүүлэх зорилтот хороог тодорхойлох уулзалт, судалгааг цувралаар зохион байгуулж, Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 17 дугаар хороог төсөл хэрэгжүүлэх талбар, нэгжээр сонголоо.

ХБНГУ-ын Дойче Велле Академийн сургагч багш Сюзанна Молл, Наталъя Раймер нар манай улсад ирж, дотоодын сургагч багш нарыг чадавхжуулах сургалт зохион байгууллаа. 2022 оны 11 дүгээр сарын 21, 22-ны өдрүүдэд болсон тус сургалтад хамрагдсан дотоодын сургагч багш нар хямрал, онцгой байдлын үед ажиллах багуудад мэдээлэл харилцааны ажлыг зохион байгуулах сургалтыг орсон юм.

Дотоодын сургагч багш нар нийгэмд хямрал, эрсдэл үүсгэж болох сэдвүүдийг хэлэлцэх, мэргэжилтнээс судалгаа, тайлбар сонсох уулзалтуудыг хийсэн. Энэ хүрээнд 2022.11.29-ний өдөр ХУИС-ийн профессор, доктор Д.Уламбаяраас “Монгол Улсын геополитикийн нөхцөл байдал” сэдвээр мэдээлэл солилцов.

Хямрал, онцгой байдлын үед ажиллах хамтарсан баг II байгуулагдлаа. Баг нь дээрх нөхцөл байдал үүссэн үед үр дүнтэй мэдээлэл харилцааны ажил явуулахад чиглэсэн сургалтад хамрагдаж, зорилтот бүлэгт хандсан мэдээлэл харилцааны туршилтын төслийг хэрэгжүүлэхэд чиглэсэн юм. Багийн гишүүдэд төрийн байгууллагыг төлөөлж: ЦХХХЯ-ны Харилцаа холбоо, гамшгийн хэрэгжилтийн асуудал хариуцсан мэргэжилтэн Ч.Отгон, ҮАБЗ-ийн дэргэдэх Стратеги судалгааны

хүрээлэнгийн Ахлах шинжээч Д.Дагийсүрэн, ЧД-ийн Онцгой байдлын хэлтсийн мэргэжилтэн Д.Ариунзаяа, хэвлэл мэдээллийг төлөөлж: Тэнгэр ТВ-ийн сэтгүүлч, продюссер Б.Батцэнгэл, Зууны мэдээ сонины сэтгүүлч П.Амгаланбаяр, GoGo.mn сайтын сэтгүүлч А.Наранцацрал, иргэд, зорилтот хороог төлөөлж: ЧД-ийн 17 дугаар хорооны Нийгмийн ажилтан М.Мөнхзул, Ерөнхий боловсролын 37-р сургуулийн Нийгмийн ажилтан Н.Батболд, хорооны иргэн Ч.Энхцэцэг нар багтаж байна.

Баг 12 дугаар сарын 5-аас эхлэн, “Хямралын мэдээллийн харилцаа”, “Хямралын үеийн талуудын үүрэг, оролцоо”, “Мэдээллийг оновчтойгоор хүргэх аргууд”, “Мэдээллийг нягтлах, үнэлэх”, “Хүртээмжтэй харилцаа холбоо тогтоох” зэрэг сэдвийн чадавхжуулах сургалтад хамрагдсан. Сургалт олон улсын хөтөлбөрийн дагуу 8 долоо хоног үргэлжилсэн бөгөөд дотоодын сургагч багш нар удирдан явууллаа.

“Хямралын мэдээллийн харилцаа - оролцогч талуудын хамтын ажиллагаа” төсөл хүрээгээ тэлж, Сэлэнгэ аймагт хэрэгжихээр болсон бөгөөд бэлтгэл ажил, судалгаа хийлээ.

Мөн Хямрал, гамшиг, ослын үед иргэдэд баталгаатай мэдээллийг түгээхэд чиглэсэн хэвлэл мэдээлэл, төр, иргэний нийгмийн оролцоо, зөвшилцөл бүхий үндэсний хэмжээний мэдээлэл харилцааны бүтэц байгуулах уулзалтуудыг зохион байгуулав.

08

“ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИНД ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДАЛ, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИХ НЬ” ТӨСЛИЙН ХҮРЭЭНД:

ХМЗ нь хариуцлагатай, ёс зүйтэй, олон ургальч хэвлэл мэдээллийг дэмжиж ажилладаг бөгөөд хэвлэл мэдээллийн агуулгад жендэрийн тэгш байдлыг хангах, жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүйг хөгжүүлэх, хэвшмэл хандлагаас зайлсхийх ёс зүйн зарчмын хүрээнд уг төсөл дээр хамтран ажиллаж байна. Уг ажлын хүрээнд энэ онд дараах ажлуудыг зохион байгууллаа.

2022 оны төслийн үйл ажиллагааны үр дүнд “чадавхжуулах” стратегийн хүрээнд 20 удаагийн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулан 371 оролцогчийг, “идэвхжүүлэх” стратегийн хүрээнд 21 уулзалт, үйл явдал зохион байгуулж 288 оролцогчийг хамрууллаа.

I улиралд:

Сэтгүүлчдэд зориулсан “Улс төрийг мэдрэмжтэй мэдээлье” редакцын сургалтыг 1 сарын 6-ны өдөр ikon.mn сайтын хамт олонд хийв.



21 аймгийн сэтгүүлчдэд зориулсан сургалтыг “Хэвлэл мэдээллийн агуулга дахь жендэрийн тэгш байдлыг дэмжих нь” сэдвийн хүрээнд “Орон нутгийн хэвлэл мэдээллийн холбоо” болон “Орон нутгийн телевизүүдийн холбоо”-той хамтран зохион байгуулсан. Сургалт нэгдүгээр сарын 12, 14-ний өдрүүдэд Улаанбаатар болон Дорноговь аймагт болов.

УИХ-д хаврын чуулганаар өргөн барихаар төлөвлөж байсан Улс төрийн намын тухай хуулийн төслийн агуулгад намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн байх, хөрөнгө оруулалт, санхүүжилт болон зарцуулалтын ил тод байдлыг хангах зэрэг чухал асуудлуудыг тусгасан. Хуулийн шинэчилсэн төсөлд эмэгтэй, эрэгтэй улс төрчдийн тэгш гарааны нөхцөлийг хэрхэн хангах талаар санал солилцох "УЛС ТӨРИЙН НАМ БА ТЭГШ ГАРАА" сэтгүүлчдийн уулзалтыг 2 сарын 21-нд зохион байгуулав.



"Улс төрийг мэдрэмжтэй мэдээлье" сэтгүүл зүйн тэтгэлэгт хөтөлбөрийг сэтгүүлч, редакторуудын мэргэжлийн ур чадвар, ёс зүйтэй ажиллах арга барилыг бэхжүүлэх, улс төрийн мэдээллийг олон ургалч байдлаар сурвалжлахад дэмжлэг үзүүлэх зорилгоор зарласан. Хөтөлбөр үндсэн сургалт, бүтээлийн тэтгэлэг гэсэн хоёр үе шаттайгаар 2022 оны 1 дүгээр сарын 21-нээс 3 дугаар сарын 1 хүртэлх хугацаанд үргэлжлэв. Энэхүү тэтгэлэгт 15 сэтгүүлчийг шалгаруулж, сэдвийн хүрээнд бүтээл гаргаж ажилласан.

3 сарын 12-нд парламентын сэтгүүлчдэд зориулсан сургалт зохион байгуулав. Сургалт “Зангиатай улс төр: Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих хэрэгцээ шаардлага”, “Яагаад бидэнд жендэрийн линз хэрэгтэй вэ?”, “Үл үзэгдэх эмэгтэйчүүд: Эх сурвалжийн хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах нь, BBC-гийн стратеги, 50:50 санаачилгад нэгдэх боломж”, “Даашинзтай улс төрч: Хэвлэл мэдээллийн агуулга дахь хэвшмэл ойлголтыг халах нь” зэрэг сэдвийн хүрээнд болж парламентын 12 сэтгүүлч хамрагдсан.

II-IV улиралд:

“Мэдрэмжтэй сэтгүүл зүй” дугуй ширээний уулзалт, хэлэлцүүлэгийг хоёр удаа зохион байгуулав.

- “Олон улсын хэвлэл мэдээлэлтэй түншлэх боломж” сэдэвт редакторуудын зөвлөлдөх уулзалтыг 2022.09.14-ний өдөр зохион байгуулав. Уулзалтын үр дүнд “Мэдрэмжтэй мэдээлье” менторшип хөтөлбөрт хамрагдсанаар Зууны мэдээ сонин, GoGo.mn сайтад гарч буй бодит өөрчлөлтийг хэвлэл мэдээллийн редакторуудад таниулсан, цаашлаад BBC агентлагийн 50:50 төсөлд хамрагдах боломжийг олгосноороо ач холбогдолтой байв.

- Сэтгүүлчдийн дунд улс төр, эдийн засаг, технологи, уул уурхай, хөдөө аж ахуйн салбарын эмэгтэй эх сурвалж, жендэрийн асуудлаар ярих эрэгтэй эх сурвалжийн дата сан бүрдүүлэх хакатоныг зохион байгууллаа. (2022.05.26-28) Хакатоны хүрээнд салбар бүрд дуу хоолойгоо түгээх боломжтой эмэгтэй эх сурвалжийн дундын сантай болсон бөгөөд дата санг редакцууд өөрсдийн эх сурвалжаар баяжуулан өргөжүүлж буй үр дүн гараад байна. Хакатон болон уулзалт, хэлэлцүүлгийн дүнд салбарын хамтын ажиллагаа сайжирсан өөрчлөлтийг авчирлаа.



"Өөрөөс нь" уулзалтыг цувралаар зохион байгуулав.

- "Өөрөөс нь" цуврал уулзалт #1-г "Улсын төсөв" сэдвээр (2022.04.22), #2-г "Her story-Тэр эмэгтэйн түүх #1 - Хэвлэл мэдээлэл дэх эмэгтэйчүүдийн улс төрийн дуу хоолой" сэдвээр (2022.04.29), #3-г "Аялал жуулчлал: Хөрөнгө оруулалт, Хүний нөөц" сэдвээр (2022.06.21), уулзалт #4-г "Her story-Тэр эмэгтэйн түүх #2 - Манлайллын түүхээ хуваалцъя" сэдвээр (2022.06.30), #5-г "Үндсэн хуулийн өөрчлөлт: Сонгуулийн тогтолцоо" сэдвээр хаалттайгаар (2022.07.01), #6-г "Малчид ба эдийн засгийн хөгжил" сэдвээр (2022.09.29) нийт 6 удаа зохион байгууллаа. Уулзалтуудыг Парламентын сэтгүүлчдийн холбоо, Эдийн засгийн сэтгүүлч, шинжээчдийн клуб, Эмэгтэйчүүдийн манлайллын сүлжээтэй хамтран тус тус зохион байгуулав. Уулзалтуудаар шийдвэр гаргах түвшинд болон нийгмийн бусад салбарт ажиллаж буй эмэгтэйчүүдийн төлөөллийг оролцуулж, тэдний түүх, ажлын туршлагыг сонсон, харилцан ярилцах боломжийг сэтгүүлчдэд олгосон. Ингэснээр эмэгтэй эх сурвалжийн дуу хоолойг нэмэгдүүлж, эмэгтэй манлайлагчдын эерэг дүрийг хэвлэл мэдээллээр сурталчилж чадлаа.

“Миний сурвалжилга - Миний түүх” чөлөөт уулзалтыг цувралаар зохион байгуулав.

- Эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулж буй сэтгүүл зүйн бүтээлээ хэрхэн гүйцэтгэсэн туршлагаа хуваалцах “Миний сурвалжилга - миний түүх” сэдэвт уулзалтыг сэтгүүлчдийн дунд 5 удаа (2022.04.08, 2022.05.16, 2022.07.06, 2022.09.17, 2022.10.07) зохион байгуулав. Оролцогчид бүтээл дээрээ ажиллах явцдаа хэвшмэл ойлголтыг багасгахын тулд санаачилгатай, оролцоотой байхын чухлыг ойлгосон, дараагийн бүтээлдээ хэвшмэл ойлголтоос ангид байж ажиллах арга барилтай болсон, цаашлаад жендэрийн тэнцвэрт байдлыг хангаж ажиллах нь хэвшил болж буй тухайгаа илэрхийлсэн юм. Түүнчлэн сэтгүүлчид бүтээлээ хийх явцдаа “Эмэгтэй эх сурвалжийн дата сан”-г ашиглан цаг хугацаагаа хэмнэсэн бөгөөд цаашид энэ сэдвээр үргэлжлүүлэн бүтээл хийх хүсэл эрмэлзлэлтэй болсон байна. Уг туршлагаа хуваалцах чөлөөт уулзалт нь сэтгүүлчид өөр хоорондоо бүтээлийн санаа, өнцгөө ярилцах, бусад сэтгүүлчдэд энэ чиглэлээр бичих сэдэл төрүүлж буй бөгөөд сэдвийн ач холбогдлыг бусад сэтгүүлчдэд ойлгуулах, эмэгтэй манлайлагчдын тухай эерэг дүр бий болгоход хувь нэмэр оруулж байна.





“Мэдрэмжтэй мэдээлье” нэгдлийн вэбинар болов.

- “Улс төр, эмэгтэйчүүд ба гадаад орны туршлага” сэдэвт цахим вэбинарыг 2022.08.25-нд, “Монголын эмэгтэйчүүдийн хэвлэлийн хөгжлийн судалгаа” вэбинарыг 2022.12.13-ны өдөр тус тус зохион байгуулав. Эдгээр үйл ажиллагаагаар Монгол Улс дахь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо түүхэн хугацаанд хэрхэн өөрчлөгдөж ирсэн, үүнд нөлөөлөх хүчин зүйлс юу байв, гадаад улс орнуудтай харьцуулахад хаана нь явж байна вэ, эмэгтэйчүүдийн хэвлэлийн хөгжлийн түүх, ололт амжилт, анхаарах зүйлс зэрэг мэдээллийг судалгаанд тулгуурлан өгсөн. Дээрх судалгааны ажлыг сэтгүүлчдэд танилцуулснаар сэтгүүлчдийг уг асуудалд баримт, нотолгоотой хандахад, бодит эх сурвалжтай болоход дэмжлэг болж чадсан. Мөн “Мэдрэмжтэй мэдээлье” нэгдлийн үйл ажиллагаанд сэтгүүлчдийн болон бусад оролцогч талуудын оролцоог нэмэгдүүллээ.



“Gender Quiz” асуулт хариултын уралдааныг цувралаар зохион байгуулав.

- “Gender Quiz” асуулт хариултын уралдааныг цахимаар 5, танхимаар 1 нийт 6 удаа зохион байгуулав. (2022.04.13, 2022.04.20, 2022.04.28, 2022.06.08, 2022.07.27, 2022.09.17) Цахим уралдааныг Мэдрэмжтэй мэдээлье нэгдлийн фэйсбүүк группээр дамжуулан явуулсан ба гишүүдэд улс төр, жендэрийн тухай мэдлэгийг сонирхолтой аргаар хүргэлээ. Ингэснээр нэгдлийн үйл ажиллагаанд сэтгүүлчдийг татан оролцуулж, хамтын ажиллагаа, үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэхэд эерэг нөлөөтэй байв.







Хэвлэлийн гэрэл зурагчин, зураглаачдад зориулсан “Мэдрэмжтэй мэдээлье” сургалтыг зохион байгууллаа. Энэ нь шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн гэрэл зургийг жендэрийн мэдрэмжтэй авах, улмаар хэвшмэл ойлголтыг гэрэл зургаар дамжуулан халахад гэрэл зураг эерэг нөлөө үзүүлэхэд зорьсон юм. Сургалтын үр дүнд “Мэдрэмжтэй мэдээлье” гэрэл зургийн үзэсгэлэнг зохион байгууллаа.

“Мэдрэмжтэй мэдээлье” нэгдлээс Их, дээд сургуулийн сэтгүүл зүйн багш нар, оюутнуудтай хамтын ажиллагаа үүсгэж ажиллалаа. Отгонтэнгэр Их сургууль, МУИС, МУБИС, СУИС, Хүмүүнлэгийн Ухааны их сургуулийн сэтгүүл зүйн багш нартай хамтарсан уулзалт, сэтгүүл зүйн оюутнуудад зориулсан хэвшмэл ойлголтоос ангид байх сургалт, өдөрлөгийг зохион байгууллаа.

Мөн сэтгүүл зүйн ангийн оюутнуудын дунд “Мэдрэмжтэй мэдээлье” мултимедиа контентын уралдааныг зохион байгуулж ажиллаж байна.

“Мэдрэмжтэй мэдээлье” редакцын сургалтыг нийт 9 редакцад зохион байгууллаа. Сургалтад хамрагдсанаар мэргэжлийн үр чадвараа сайжруулахад эергээр нөлөөлсөн, мэргэжлийн алдаа дутагдлаа олж харсан, хандлагын өөрчлөлт авчирсан цаашид редакцаас гарч буй бүтээлүүд дээрээ дүн шинжилгээ хийж, сайжруулах хүсэлтэй болсон зэрэг үр дүн гарсныг оролцогчид хэлж байв.

“Мэдрэмжтэй мэдээлье” менторшип хөтөлбөр GoGo.mn сайт, Зууны мэдээ сонин, Архангай медиа групп, Монголын үндэсний олон нийтийн радиогийн Хурд агентлаг, Пи 3 суваг гэсэн таван редакцыг сонгож, менторшип хөтөлбөрийг хэрэгжүүлэв. Хөтөлбөрийн үр дүнд редакцууд эх сурвалжийн бүртгэл хөтлөх шинэ аргачлалыг нэвтрүүлж, дата сан ашиглалтыг өдөр тутмын дадал болгож хэвшүүлсэн, жендэрийн хэвшмэл

ойлголтыг халахад чиглэсэн бүтээлүүд гаргасан, жендэрийн мэдрэмжтэйгээр ажиллах арга барилтай болоод байна. Менторшип хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад жендэрийн тухай хэвшмэл ойлголтыг халж, эмэгтэйчүүдийн манлайллыг дэмжих зорилгоор GoGo сайт нь "Тэнцвэр" санаачилга, Зууны мэдээ сонин "Хэвшмэл ойлголтоо халъя", "Эмэгтэйчүүдийн манлайлал" Архангай медиа групп "Мэдрэмжтэй бүтээнэ" булан, Пи 3 радиогийн суваг нь "Аав бид хоёр" зорилтот нэвтрүүлгүүдийг санаачилж эхлүүлээд байна.



09

МЭДЭЭЛЭЛ СУРТАЛЧИЛГААНЫ ХЭВЛЭМЭЛ БҮТЭЭГДЭХҮҮНҮҮД

ХМЗ-өөс 2022 онд дараах гарын авлага, танилцуулга, тараах материал, сурталчилгааны бүтээгдэхүүнийг бэлтгэж, сэтгүүл зүйн салбарынхан болон бусад зорилтот бүлэгт түгээв.

“ХМЗ-ийн 2020- 2021 оны үйл ажиллагааны тайлан” англи, монгол хэлээр

“Улс төрийн мэдээллийн агуулгад жендэрийн тэгш байдлыг хангах нь” редакцад зориулсан удирдамж, монгол хэлээр

“Мэдрэмжтэй мэдээлье” төслийн танилцуулга, англи хэлээр

“Хямралын мэдээлэл харилцаа ба оролцогч талуудын хамтын ажиллагаа” төслийн танилцуулга монгол, англи хэлээр

10

ДОТООДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА, ТҮНШЛЭЛ

Хэвлэл мэдээллийн салбарын эрх зүйн орчинг сайжруулах, хэвлэлийн эрх чөлөөг баталгаажуулах, сэтгүүлчийн ёс зүйн хэм хэмжээг дээшлүүлэх чиглэлээр ажилладаг олон улсын байгууллагууд болох Европын Холбоо, Дойче Велле Академи, НҮБ-ын суурин төлөөлөгчийн газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Европын Аюулгүй байдал, Хамтын ажиллагааны нийгэмлэг, Фридрих-Эбертийн сан, Ханнс-Зайделын сан, Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн зэрэг байгууллагуудтай хамтын ажиллагаа хөгжүүллээ.

Мөн "Хямралын мэдээллийн харилцаа ба оролцогч талуудын хамтын ажиллагаа" төслийн хүрээнд БЗД-ийн 23 дугаар хороо, БЗД-ийн 23 дугаар хорооны "Нэмүүлэн" ӨЭМТ, ЧД-ийн 17 дугаар хороо, Нийслэлийн ерөнхий боловсролын 87-р сургууль, Нийслэлийн ерөнхий боловсролын 37-р сургууль, Засгийн газрын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба, Онцгой байдлын ерөнхий газар, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Эрүүл мэндийн сэтгүүлчдийн "Цагаан үзэг" холбоо, Монголын үндэсний олон нийтийн телевиз, Mpress.mn сайт, Зууны мэдээ сонин, Тэнгэр телевиз, GoGo.mn сайт, Эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төв, Factcheck.mn, Сэтгүүл зүйн инноваци хөгжлийн үүр төв зэрэг байгууллагуудтай хамтран ажилласан.

Түүнчлэн "Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь" төслийн хүрээнд Анлимитед медиа групп зэрэг үндсэн хамтрагчдаас гадна Эдийн засгийн сэтгүүлч, шинжээчдийн клуб, Парламентын сэтгүүлчдийн холбоо, Гэрэл зурагчдын нэгдсэн холбоо, Либерал Эмэгтэйчүүдийн Оюуны сан, Эмэгтэйчүүдийн манлайллын сүлжээ, сэтгүүл зүйн их дээд сургуулиуд зэрэг дотоодын болон BBC-ийн 50:50 төсөл, Интерньюс, FIPP Media зэрэг байгууллагуудтай хамтран ажиллав.

Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтыг дэмжиж хэвлэл мэдээллийн болон бизнесийн байгууллагууд санхүү болон үйл ажиллагааны дэмжлэг үзүүллээ.

- МҮОНРТВ,
- NTV телевиз,
- Монгол ТВ ХХК,
- Бенекрафт ХХК,
- Монгол Контент ХХК,
- Mpress.mn сайт,
- Зууны мэдээ сонин,
- Үнэн сонин,
- Өдрийн сонин,
- Орон нутгийн хэвлэл мэдээллийн холбоо,
- Орон нутгийн телевизүүдийн холбоо,
- Харилцаа холбооны зохицуулах хороо,
- Мэдээлэл холбооны операторуудын ассоциаци,
- А стар Монголиа ХХК

11

САНХҮҮЖИЛТ

2022 онд ХМЗ нийт 664,548,958.59 төгрөгийн мөнгөн орлоготой, нийт 750,548,009.07 төгрөгийн мөнгөн зардалтай ажиллажээ. Орлогын бүрдэлт: дотоод эх үүсвэр 10%, төсөл хөтөлбөрийн эх үүсвэр 90%.

Орлогын эх үүсвэр нь хэвлэл мэдээллийн байгууллагуудын дэмжлэг, сургалт үйлчилгээний орлого, төслийн үйл ажиллагааны орлогоос бүрдэж байна. ХМЗ-ийн үйл ажиллагааны зардлыг төрлөөр харуулбал:

- Цалин, даатгал, татварын зардал 13%
- Ашиглалтын болон үйл ажиллагааны тогтмол зардал 7%
- Төслийн үйл ажиллагааны зардал 80%

2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд Голден пэйж аудит ХХК шалгалт хийж, “Зөрчилгүй” дүгнэлт гаргав.





2022 онд ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ӨӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ ДЭМЖСЭН БАЙГУУЛЛАГУУД

НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГА МОНГОЛ УЛС
KOICA Korea International Cooperation Agency
World Health Organization
OSCE
MCIR Mongolian Center for Investigative Reporters
UNDP
DW Akademie
германы хамтын ажиллагаа
FRIEDRICH EBERT STIFTUNG
UNFPA НҮБ-ын Хүн Амын Сан
British Embassy Ulaanbaatar
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО
21 РАДИО ТЕЛЕВИЗ СОНИН САЙТ АЙМАГ
Мэдээлэл Холбооны Операторуудын Ассоциаци
НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ
news agency
МОНГОЛТV
MNB
ГЛОБ ИНТЕРНЭШНЛ ТӨВ
МОНГОЛЫН САЙТЫН ХОЛБОО
ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРОО
ТӨР
gogo NEWS AGENCY
ikon next horizon
ӨДРИЙН СОНИН
LIVETV
ntv
A STAR MONGOLIA
ЗУУНЫ Мэдээ
UB.LIFE
ОРОН НУТГИЙН ТЕЛЕВИЗҮҮДИЙН ХОЛБОО
c1
TIME
UNLIMITED MEDIA GROUP
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
MEDIA GROUP
Urug Mongolian Independent Media
Ид шидийн орон
Mongol Content
FIPP Connecting Global Media
Бодлогод залуусын хяналт
peak
Eguur.mn
9tv
ХАЛДВАРТ ӨРҮНҮ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ
Internews Local voices. Global change.
МОНГОЛЫН ҮНЭН
ЭДИЙН ЗАСГИЙН СЭТГҮҮЛЧ, ШИНЖЭЭЧДИЙН КЛУБ
Nest Center
ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН МАНЛАЙЛЫН СҮЛЖЭЭ
ubn
МОНЦАМЭ МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ МЭДЭЭЛЛИЙН АГЕНТЛАГ
LEOS
МОНГОЛЫН ГЭРЭЛ ЗУРАГЧДЫН НЭГДСЭН ХОЛБОО
50:50 THE EQUALITY PROJECT
mpress.mn Тэгш эрхийн төлөө...

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЗӨВЛӨЛ